



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/162/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112 Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 “Өндөрхаан итгэл аудит” ХХК-ийн: Аудитор: Б.Маналсүрэн Утас: 99059424</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	10
4.1 Залруулсан алдаа	10
4.2 Төлбөрийн акт	10
4.3 Албан шаардлага	10
4.4 Зөвлөмж	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.03.᠒3 № ᠒84

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030580

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,957,221.74	37,861,342.64
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	89,100.00	767,248.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	767,248.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	89,100.00	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	40,868,121.74	37,094,101.64
351	Түүхий эд материал	372,900.00	342,450.00
35130	Эм боох материал	372,900.00	342,450.00
354	Хангамжийн материал	40,495,221.74	36,751,651.64
35410	Бичиг хэргийн материал	2,076,240.10	1,930,240.00
35420	Аж ахуйн материал	3,851,050.00	3,706,150.00
35440	Түлш, шатах тослох материал	3,161,270.00	1,317,000.00
35450	Барилгын засварын материал	4,936,600.00	3,636,000.00
35460	Хүнсний материал	4,335,450.00	5,806,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,134,611.64	20,356,261.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	193,157,933.03	206,896,007.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	193,157,933.03	206,896,007.32
392	Биет хөрөнгө	180,877,933.03	194,616,007.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	179,895,500.00	214,884,216.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(29,860,620.48)	(45,621,188.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,385,403.14	29,923,000.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,100,481.79)	(18,335,852.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,961,820.00	33,372,520.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,342,473.50)	(22,545,474.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39217	Ном	2,938,785.66	2,938,785.66
393	Биет бус хөрөнгө	12,280,000.00	12,280,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,280,000.00	12,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II	234,115,154.77	244,757,356.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	89,100.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,100.00	-
413	Өглөг	89,100.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	89,100.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	89,100.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	234,026,054.77	244,757,356.96
51	Засгийн газрын хувь оролцоо	234,026,054.77	244,757,356.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	75,661,189.00	75,661,189.00
51101	Өмч: - төрийн	75,661,189.00	75,661,189.00
512	Хуримтлагдсан үр дүн	34,095,493.50	44,826,795.69
51210	Өмнөх үеийн үр дүн	34,095,493.50	34,095,493.50
51220	Тайланг үеийн үр дүн	-	10,731,302.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,269,372.27	124,269,372.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	234,115,154.77	244,757,356.96

Гурванбаян тосгоны цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	226,231,850.00	227,980,816.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,190,350.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	6,190,350.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,190,350.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,190,350.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	220,041,500.00	227,980,816.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	190,748,300.00	167,566,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	190,748,300.00	167,566,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	35,125,316.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	35,125,316.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,293,200.00	25,289,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,293,200.00	25,289,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	227,784,540.59	217,249,513.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	227,784,540.59	217,249,513.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,220,496.85	207,809,496.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,681,404.00	126,134,750.00
210101	Үндсэн цалин	90,470,819.00	93,183,092.00
210102	Нэмэгдэл	25,411,156.00	22,790,313.00
210104	Урамшуулал	8,799,429.00	10,161,345.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,942,963.74	17,902,484.00
210201	Тэтгэврийн даатгал	11,965,017.99	12,895,344.03
210202	Тогтмолжийн даатгал	1,246,814.04	1,261,347.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	997,451.24	1,009,078.04
210204	Ажилгүйдлийн даатгал	240,052.39	240,718.57
210205	Эрүүл мэндийн даатгал	2,493,628.08	2,495,995.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,536,076.00	26,179,901.00
210301	Гэрэл, цахилгаан	1,657,076.00	2,565,901.00
210302	Түлш, халаалт	21,879,000.00	22,614,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,979,452.00	6,427,570.10
210401	Бичиг хэрэг	705,400.00	1,338,900.10
210402	Тээвэр, шатахуун	216,000.00	534,270.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	749,300.00	900,000.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	38,900.00	183,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,269,852.00	3,470,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	9,963,366.50	6,986,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,600.00	25,900.00
210502	Хоол, хунс	9,942,766.50	6,555,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	-	404,700.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	344,400.00	1,300,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	344,400.00	1,300,600.00
2107	Томилголт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилголт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,448,834.61	22,553,641.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,570.00	1,303,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	19,714,264.61	21,250,641.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,564,043.74	9,440,017.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,332,124.00	434,099.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,332,124.00	434,099.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,831,919.74	8,705,918.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,831,919.74	8,705,918.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,552,690.59)</u>	<u>10,731,302.19</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(1,552,690.59)</u>	<u>10,731,302.19</u>

Гурванбаян тосгоны цэцэрлэг

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,661,189.00	124,269,372.27	35,648,184.09	235,578,745.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,661,189.00	124,269,372.27	35,648,184.09	235,578,745.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,552,690.59)	(1,552,690.59)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,661,189.00	124,269,372.27	34,095,493.50	234,026,054.77
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	75,661,189.00	124,269,372.27	34,095,493.50	234,026,054.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,661,189.00	124,269,372.27	34,095,493.50	234,026,054.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	10,731,302.19	10,731,302.19
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,661,189.00	124,269,372.27	44,826,795.69	244,757,356.96

Гурванбаян тосгоны цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Гергээр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	220,041,500.00	227,980,816.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	220,041,500.00	227,980,816.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	190,748,300.00	167,566,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	190,748,300.00	167,566,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	35,125,316.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	35,125,316.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,293,200.00	25,289,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,293,200.00	25,289,200.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	220,041,500.00	192,992,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,041,500.00	192,992,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,388,356.26	183,552,083.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,775,477.52	127,070,899.00
210101	Үндсэн цалин	79,999,476.00	87,942,539.00
210102	Нэмэгдэл	37,976,572.52	29,365,608.00
210104	Урамшуулал	8,799,429.00	9,762,752.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,497,747.74	17,733,583.00
210201	Тэтгэврийн даатгал	11,484,041.03	12,480,854.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,296,543.40	1,313,155.00
210203	УОМШӨ-ний даатгал	1,023,874.31	1,050,565.00
210204	Ажилгүйдлийн даатгал	254,405.65	262,590.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,438,883.35	2,626,419.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,261,076.00	24,369,901.00
210301	Гэрэл, цахилгаан	1,657,076.00	2,565,901.00
210302	Түлш, халаалт	21,604,000.00	20,804,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,991,725.00	3,546,100.00
210401	Бичиг хэрэг	1,046,100.00	183,400.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	725,000.00	900,000.00
210404	Ном, хэвлэл	24,300.00	28,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,156,325.00	1,694,500.00
2105	Нормативт зардал	9,596,130.00	8,301,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,900.00	25,900.00
210502	Хоол, хүнс	8,083,630.00	8,026,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,486,600.00	248,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	485,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,300,000.00	-
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	4,700,000.00	485,200.00
2107	Томилот, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,942,200.00	1,721,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,300.00	68,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,873,900.00	1,653,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,653,143.74	9,440,017.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,332,124.00	434,099.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,332,124.00	434,099.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,921,019.74	8,705,918.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,921,019.74	8,705,918.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	34,988,716.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	34,988,716.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	34,988,716.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	34,988,716.00
221001	Их засвар	-	34,988,716.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(34,988,716.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	192,855,500.00	183,715,483.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,855,500.00	183,715,483.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,555,500.00	183,415,483.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,712,400.00	127,070,899.00
210101	Үндсэн цалин	88,870,500.00	87,942,539.00
210102	Нэмэгдэл	31,677,900.00	29,365,608.00
210104	Урамшуулал	10,164,000.00	9,762,752.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,764,200.00	17,733,583.00
210201	Тэтгэврийн даатгал	12,500,800.00	12,480,854.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,315,800.00	1,313,155.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,052,700.00	1,050,565.00
210204	Ажлын үйлдлийн даатгал	263,100.00	262,590.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,631,800.00	2,626,419.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,804,000.00	24,369,901.00
210301	Гэрэл, цахилгаан	3,900,000.00	2,565,901.00
210302	Түлш, халаалт	19,404,000.00	20,804,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,409,500.00	3,409,500.00
210401	Бичиг хэрэг	46,100.00	183,400.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,037,300.00	900,000.00
210404	Ном, хэвтэл	28,200.00	28,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзгэдэх, ахуйн эд зүйлс	1,557,900.00	1,557,900.00
2105	Нормативт зардал	13,287,700.00	8,301,000.00
210501	Эм, болдмал, эмгэгчдийн хэрэгсэл	25,900.00	25,900.00
210502	Хоол, хүнс	13,013,200.00	8,026,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	248,600.00	248,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,200.00	485,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	485,200.00	485,200.00
2107	Томилголт, зочны зардал	47,100.00	-
210702	Дотоод албан томилголт	47,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,721,400.00	1,721,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,400.00	68,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,653,000.00	1,653,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	192,855,500.00	183,715,483.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	167,566,300.00	158,860,382.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	167,566,300.00	158,860,382.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,289,200.00	24,855,101.00
132001	Орон нутгийн төсвөөс	25,289,200.00	24,855,101.00

Гурванбаян тосгоны цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	35,125,316.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	136,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	136,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	136,600.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	136,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	34,988,716.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	34,988,716.00
221001	Их засвар	-	34,988,716.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	35,125,316.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	35,125,316.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	35,125,316.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор П.Мөнгөнтуул, аудиторын туслах Ж.Батсайхан нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 227,784.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,277.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,822.3 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 1,738.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,642.2 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	89.10	767.30	678.20
Урьдчилгаа			-
Бараа материал	40,868.10	37,094.10	(3,774.00)
Үндсэн хөрөнгө	193,158.00	206,896.00	13,738.00
Нийт хөрөнгө	234,115.20	244,757.40	10,642.20
Өр төлбөр	89.10		(89.10)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	234,026.10	244,757.40	10,731.30
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	75,661.20	75,661.20	-
Хуримтлагдсан үр дүн	34,095.50	34,095.50	-
Тайлант үеийн үр дүн		10,731.30	10,731.30
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,269.40	124,269.40	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	234,115.20	244,757.40	10,642.20

Тайлант онд авлага 678.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь 37,094.1 мянган төгрөг болж 3,774.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 13,717.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 17,491.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,342.3 мянган төгрөгийн бараа материал актласанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 206,896.0 мянган төгрөг болж 13,738.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 34,988.7 мянган төгрөгийн барилгын их засвар хийж капиталжуулсантай холбоотой.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 44,826.8 мянган төгрөг болж, 10,731.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлсөн байна.

Урьд оны 89.1 мянган төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,749.0 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй авсан орлого 6,190.3 мянган төгрөг, санхүүжилтийн орлого 27,186.0 мянган төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 35,125.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 10,535.0 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл хоол хүнсний зардал 3,386.9 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал 1,798.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 291,717.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 98,861.7 мянган төгрөгөөр бууруулан 192,855.5 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: түлш халаалтын зардлыг 4,004.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 676.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 93,812.2 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 192,855.5 мянган төгрөгөөр баталсанаас 167,566.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 25,289.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 167,566.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 25,289.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 183,715.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 8,705.9 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 434.1 төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 183,715.5 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь гэрэл цахилгааны зардлыг 1,334.1 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 3,641.5 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 4,986.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 35.125.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд оруулбал зохих 144 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж, өгсөн зөвлөмж байхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,286.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,944.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,342.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 1,944.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө. Үүнд:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн 2 ажилтны оронд нөхөн томилгоо хийж 1,335.0 мянган төгрөгийн цалин, 11 ажилтанд 609.4 мянган төгрөгийн шагнал урамшуулал нийт 1,944.4 мянган төгрөг олгосон нь ЗГ-ын 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

4.4.1. Эрхлэгчийн тушаал шийдвэргүйгээр 1,342.3 мянган төгрөгийн бараа материал актласан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг давтахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Гурванбаян тосгоны Цэцэрлэг	2	3,286.7					1	1,944.4	1	1,342.3
	Дүн	2	3,286.7					1	1,944.4	1	1,342.3



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 208/23910610
ХЭА 2022/162/НА-ЭТА ТУС

Чингис хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Гурванбаян тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн 2 ажилтны оронд нөхөн томилгоо хийж 1,335.0 мянган төгрөгийн цалин, 11 ажилтанд 609.4 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.2 "Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтны оронд нөхөн томилгоо хийхгүй байх" 1.3-д "Шагнал урамшуулал олгохгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8 "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч М.Ундармаа, нягтлан бодогч Ч.Уянганэмэх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР



Б.МАНАЛСҮРЭН

Д.ОЮУНТУЯА